УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баруунтуруун сумын Соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:** УВА-2022/138/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Улаангом хот

2022 он

Увс аймаг дахь Төрийн аудитын газар,

Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь

Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn

Аудитын менежер: М.Бат-Амгалан

Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn

Аудитор: Р.Аюуш

Утас: 70453721, Цахим хаяг: ayushr@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу

## Агуулга

1. Аудитын санал дүгнэлт ..... 3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ..... 4
3. Аудитын тайлан ..... 13
  3.1 Ерөнхий зүйл ..... 13
  3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ..... 13
  3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ..... 14
  3.4 Материаллаг байдал ..... 14
  3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга ..... 14
  3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ..... 14
  3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг ..... 16
  3.8 Аудитын гол асуудал ..... 16
  3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ..... 16
  3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ..... 17
  3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал ..... 17
4. Аудитын илрүүлэлт ..... 17
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ..... 18

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
20
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

20
УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

БАРУУНТУРУУН СУМЫН СОЁЛЫН ТӨВИЙН ЭРХЛЭГЧ Ч.НЯМСҮРЭН ТАНАА


УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn


2022.02.21 № УВА-2022/138/НА-СТА-ТҮЗ
танай ______ -ны № ______ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баруунтуруун сумын Соёлын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баруунтуруун сумын Соёлын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР М.БАТСУУРЬ

0200200023

## 2.1. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

| | | | /Төгрөгөөр/ |
|---|---|---|---|
| **Дансны код** | **Балансын үзүүлэлт** | **Эхний үлдэгдэл** | **Эцсийн үлдэгдэл** |
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **18,793,520.00** | **18,793,520.00** |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **18,793,520.00** | **18,793,520.00** |
| 354 | Хангамжийн материал | 18,793,520.00 | 18,793,520.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 9,359,620.00 | 9,359,620.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 4,303,400.00 | 4,303,400.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 5,130,500.00 | 5,130,500.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **640,173,856.39** | **626,328,233.56** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **640,173,856.39** | **626,328,233.56** |
| 392 | Биет хөрөнгө | 631,785,856.39 | 617,940,233.56 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 606,260,320.20 | 606,260,320.20 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -20,490,839.52 | -30,736,259.28 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 55,275,098.00 | 56,905,098.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -43,737,686.50 | -47,271,803.16 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 28,708,829.00 | 28,708,829.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -23,210,369.79 | -24,906,456.20 |
| 39213 | Түүх соёл, музейн дурсгалт зүйлс | 9,780,000.00 | 9,780,000.00 |
| 39217 | Ном | 19,200,505.00 | 19,200,505.00 |
| 393 | Биет бус хөрөнгө | 8,388,000.00 | 8,388,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 8,388,000.00 | 8,388,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **658,967,376.39** | **645,121,753.56** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **90,000.00** | **00.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **90,000.00** | **00.00** |
| 413 | Өглөг | 90,000.00 | 00.00 |
| 4136 | Бусад өглөг | 90,000.00 | 00.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 90,000.00 | 00.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **658,877,376.39** | **645,121,753.56** |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 658,877,376.39 | 645,121,753.56 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 629,021,982.01 | 629,021,982.01 |
| 51101 | Өмч: - төрийн | 629,021,982.01 | 629,021,982.01 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 24,655,692.75 | 10,900,069.92 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 24,655,692.75 | 24,655,692.75 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | -13,755,622.83 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 5,199,701.63 | 5,199,701.63 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **658,967,376.39** | **645,121,753.56** |

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
20 ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 2.2. АУДИТ ХИЙСЭН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

**/Төгрөгөөр/**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **135,187,505.00** | **104,509,400.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **26,930,505.00** | **150,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 26,930,505.00 | 150,000.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 26,930,505.00 | 150,000.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 650,000.00 | 150,000.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 26,280,505.00 | 00.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **108,257,000.00** | **104,359,400.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 3,600,000.00 | 00.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 3,600,000.00 | 00.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 104,657,000.00 | 104,359,400.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 104,657,000.00 | 104,359,400.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **119,918,300.70** | **118,265,022.83** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **119,918,300.70** | **118,265,022.83** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 118,105,501.76 | 117,356,782.72 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 58,402,752.09 | 56,621,856.43 |
| 210101 | Үндсэн цалин | 53,362,752.09 | 52,421,856.43 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 5,040,000.00 | 4,200,000.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 7,192,483.37 | 7,296,163.46 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 4,490,984.93 | 5,095,968.58 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 993,273.13 | 566,218.75 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 465,574.50 | 452,974.99 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 112,314.57 | 107,363.75 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 1,130,336.24 | 1,073,637.39 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 26,563,000.00 | 29,068,440.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 712,100.00 | 212,100.00 |
| 210302 | Түлш, халаалт | 25,850,900.00 | 28,856,340.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 2,815,000.00 | 2,277,200.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 491,200.00 | 444,100.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,729,300.00 | 1,353,100.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 360,000.00 | 200,200.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 59,500.00 | 40,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 175,000.00 | 239,800.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 458,730.00 | 00.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 458,730.00 | 00.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 330,000.00 | 3,918,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 150,000.00 | 453,700.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 180,000.00 | 83,300.00 |
| 210604 | Урсгал засвар | 00.00 | 3,381,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 250,000.00 | 133,500.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 250,000.00 | 133,500.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 3,032,900.00 | 2,566,000.00 |

20 ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | |
|---|---|---|---|
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,942,900.00 | 1,176,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 90,000.00 | 216,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 00.00 | 1,174,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 19,060,636.30 | 15,475,622.83 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 19,060,636.30 | 15,475,622.83 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 1,812,798.94 | 908,240.11 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 300,000.00 | 400,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 300,000.00 | 400,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 1,512,798.94 | 508,240.11 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,512,798.94 | 508,240.11 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **15,269,204.30** | **-13,755,622.83** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **15,269,204.30** | **-13,755,622.83** |

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
20
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

## 2.3. АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

| | | | /Төгрөгөөр/ |
|---|---|---|---|
| **Дансны код** | **Үзүүлэлт** | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **108,907,000.00** | **104,509,400.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | 650,000.00 | 150,000.00 |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 650,000.00 | 150,000.00 |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 650,000.00 | 150,000.00 |
| **1200041** | **Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих** | 650,000.00 | 150,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **108,257,000.00** | **104,359,400.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **3,600,000.00** | **00.00** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 3,600,000.00 | 00.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 104,657,000.00 | 104,359,400.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 104,657,000.00 | 104,359,400.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **108,907,000.00** | **102,879,400.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **108,907,000.00** | **102,879,400.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **107,094,201.06** | **102,121,159.89** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **59,805,017.69** | **56,621,856.43** |
| 210101 | Үндсэн цалин | 54,765,017.69 | 51,581,866.43 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 5,040,000.00 | 5,039,990.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **7,192,483.37** | **7,296,163.46** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 4,490,984.93 | 5,095,968.58 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 993,273.13 | 566,218.75 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 465,574.50 | 452,974.99 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 112,314.57 | 107,363.75 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 1,130,336.24 | 1,073,637.39 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **26,563,000.00** | **29,068,440.00** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 712,100.00 | 212,100.00 |
| 210302 | Түлш, халаалт | 25,850,900.00 | 28,856,340.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **2,568,800.00** | **1,943,200.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 245,000.00 | 204,100.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,729,300.00 | 1,353,100.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 360,000.00 | 200,200.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 59,500.00 | 40,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 175,000.00 | 145,800.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **498,000.00** | **100,000.00** |
| **210503** | **Нормын хувцас, зөөлөн эдлэл** | 498,000.00 | 100,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **4,630,000.00** | **3,918,000.00** |
| **210601** | **Багаж, техник, хэрэгсэл** | 4,030,000.00 | 453,700.00 |
| **210603** | **Хөдөлмөр хамгааллын хэрэглэл** | 100,000.00 | 83,300.00 |
| **210604** | **Урсгал засвар** | 500,000.00 | 3,381,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **250,000.00** | **133,500.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 250,000.00 | 133,500.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 5,586,900.00 | 3,040,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 5,496,900.00 | 1,650,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 90,000.00 | 216,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 00.00 | 1,174,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **1,812,798.94** | **758,240.11** |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 300,000.00 | 250,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 300,000.00 | 250,000.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 1,512,798.94 | 508,240.11 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,512,798.94 | 508,240.11 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | 00.00 | **1,630,000.00** |
| | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | 00.00 | 00.00 |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | 00.00 | **1,630,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | 00.00 | **1,630,000.00** |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 00.00 | 1,630,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 00.00 | 1,630,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | 00.00 | -1,630,000.00 |
| | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | 00.00 | 00.00 |
| **7** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | 00.00 | 00.00 |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 00.00 | 00.00 |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 00.00 | 00.00 |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 00.00 | 00.00 |

20 УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 2.4. АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2020 оны 01-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **00.00** | **00.00** | **00.00** | **00.00** | 00.00 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C08 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **629,021,982.01** | **5,199,701.63** | **24,655,692.75** | **00.00** | **658,877,376.39** |
| D01 | **2021 оны 01-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **629,021,982.01** | **5,199,701.63** | **24,655,692.75** | **00.00** | **658,877,376.39** |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **629,021,982.01** | **5,199,701.63** | **24,655,692.75** | **00.00** | **658,877,376.39** |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -13,755,622.83 | 00.00 | -13,755,622.83 |
| D09 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **629,021,982.01** | **5,199,701.63** | **10,900,069.92** | **00.00** | **645,121,753.56** |

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
20
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

## 2.5. АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **104,359,400.00** | **104,001,159.89** | **358,240.11** | **99.7%** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **104,359,400.00** | **104,001,159.89** | **358,240.11** | **99.7%** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **104,109,400.00** | **103,751,159.89** | **358,240.11** | **99.7%** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **56,621,900.00** | **56,621,856.43** | **43.57** | **100%** |
| 210101 | Үндсэн цалин | 51,581,900.00 | 51,581,866.43 | 33.57 | 100% |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 5,040,000.00 | 5,039,990.00 | 10.0 | 100% |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **7,644,000.00** | **7,296,163.46** | **347,836.54** | **95.4%** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 5,379,100.00 | 5,095,968.58 | 283,131.42 | 94.7 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 566,200.00 | 566,218.75 | -18.75 | 100% |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 453,000.00 | 452,974.99 | 45.01 | 100% |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 113,300.00 | 107,363.75 | 5,916.25 | 94.8% |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 1,132,400.00 | 1,073,637.39 | 58,762.61 | 94.8% |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **29,068,800.00** | **29,068,440.00** | **360.00** | **100%** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 212,100.00 | 212,100.00 | 00.00 | 100% |
| 210302 | Түлш, халаалт | 28,856,700.00 | 28,856,340.00 | 360.00 | 100% |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **1,953,200.00** | **1,943,20.00** | **10,000.00** | **99.5%** |
| 210401 | Бичиг хэрэг | 204,100.00 | 204,100.00 | 0.00 | 100% |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,353,100.00 | 1,353,100.00 | 0.00 | 100% |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 200,200.00 | 200,200.00 | 0.00 | 100% |
| 210404 | Ном, хэвлэл | 50,000.00 | 40,000.00 | 10,000.00 | 80% |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 145,800.00 | 145,800.00 | 00.00 | 100% |
| **2105** | **Нормативт зардал** | **100,000.00** | **100,000.00** | **00.00** | **100%** |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 100,000.00 | 100,000.00 | 00.00 | 100% |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **5,548,000.00** | **5,548,00.00** | **00.00** | **100%** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 2,083,700.00 | 2,083,700.00 | 00.00 | 100% |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 83,300.00 | 83,30.00 | 00.00 | 100% |
| 210604 | Урсгал засвар | 3,381,000.00 | 3,381,00.00 | 00.00 | 100% |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **133,500.00** | **133,500.00** | **00.00** | **100%** |
| 210702 | Дотоод албан томилолт | 133,500.00 | 133,500.00 | 00.00 | 100% |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 3,040,000.00 | 3,040,000.00 | 00.00 | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,650,000.00 | 1,650,000.00 | 00.00 | 100% |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 216,000.00 | 216,000.00 | 00.00 | 100% |
| 210806 | Мэдээллийн технологийн зардал | 1,174,000.00 | 1,174,000.00 | 00.00 | 100% |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 250,000.00 | 250,000.00 | 00.00 | 100% |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 250,000.00 | 250,000.00 | 00.00 | 100% |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 250,000.00 | 250,000.00 | 00.00 | 100% |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 104,359,400.00 | 104,001,159.89 | 358,240.11 | 99.7% |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 104,359,400.00 | 104,001,159.89 | 358,240.11 | 99.7% |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 104,359,400.00 | 104,001,159.89 | 358,240.11 | 99.7% |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 0.00 | 150,000.00 | 150,000.00 | |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 0.00 | 150,000.00 | 150,000.00 | |

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР 20 ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Баруунтуруун сумын Соёлын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Р.Аюуш гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Баруунтуруун сумын Соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 01 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Баруунтуруун сумын Соёлын төв нь “Соёлын үнэт зүйлийг өвлөн хамгаалж,түгээн дэлгэрүүлж бүх нийтэд соёл урлагийн боловсролыг эзэмшүүлж, авьяас билгийг нээн хөгжүүлнэ. Орон нутгийн болон аймаг бүсийн хэмжээнд соёл урлагийн үйлчилгээг иргэдэд хүргэж Соёлын өв уламжлалыг хүүхэд залуучуудад сурталчлан таниулж, өвлүүлэн үлдээхэд оршино" гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг төсвийн тухай хуульд өөрчлөлт орсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын хэлтэс эрсдэлд суурилсан дотоод аудит хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР 20 ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баруунтуруун сумын Соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 119,918.3 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 1,199.2 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 118,265.0 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 1,182.7 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Төлөвлөлтийн шатанд 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан гараагүй байсан учраас материаллаг байдлыг 2020 оны жилийн эцсийн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1 хувиар тогтоон, гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1 хувиар шинэчлэн тогтоох нь зүйтэй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Баруунтуруун сумын Соёлын төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 13,845.6 мянган төгрөгөөр буюу 2.1 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь үндсэн хөрөнгийн данс байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 0.0 | 0.0 | 0.0 |
| Авлага | 0.0 | 0.0 | 0.0 |
| Бараа материал | 18,793.5 | 18,793.5 | 0.0 |
| Үндсэн хөрөнгө | 640,173.9 | 626,328.2 | -13,845.7 |
| **Нийт хөрөнгө** | 658,967.4 | 645,121.8 | -13,845.7 |
| Өр төлбөр | 90.0 | 0.0 | -90.0 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 658,877.4 | 645,121.8 | -13,755.6 |

| | | | |
|---|---|---|---|
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | 658,967.4 | 645,121.8 | -13,845.7 |

Тайлант оны эхэнд болон эцэст мөнгөн хөрөнгийн данс үлдэгдэлгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 18,793.5 мянган төгрөг байгаа нь бичиг хэрэг материал, аж ахуйн материал, бусад хангамжийн материалын үлдэгдэл байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 625,328.2 мянган төгрөг болж 13,845.7 мянган төгрөгөөр буурсан нь элэгдлийн зардлаас шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 645,121.8 мянган төгрөг болж 13,755.6 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үндсэн хөрөнгийн элэгдлээс шалтгаалжээ.

2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 30,678.1 мянган төгрөгөөр буюу 29.4 хувиар буурсан байна.

Нийт зардал өмнөх оноос 1,653.3 мянган төгрөгөөр буюу 1.4 хувиар буурсан байна. Энэ нь хангамж, бараа материалын зардал, үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдлын зардлууд байна.

Тайлант онд өр төлбөр үүсээгүй байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар нягтлан бодох бүртгэлийн залруулга хийгдээгүй байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Баруунтуруун сумын Соёлын төвийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 140,452.7 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 140,452.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 36,093.3 мянган төгрөгөөр бууруулж 104,359.4 мянган төгрөгөөр баталсан байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 104,359.4 мянган төгрөгийн төсөв батласнаас 104,359.4 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 104,359.4 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 150.0 мянган төгрөг, нийт 104,509.4 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 104,001.2 мянган төгрөгийг зарцуулж, 508.2 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 104,001.2 мянган төгрөг буюу 99.7 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төсвийн нэмэлт санхүүжилтийн данс байхгүй болно.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

АОУС 706.7-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

### 3.8 Аудитын гол асуудал

АОУС 706.1-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан ерөнхий чиглэлийн дагуу Санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх онд зөвлөмж, албан шаардлага өгсөн болон эрсдэл бүхий байгууллагыг түүвэрт хамруулан шалгасан. Баруунтуруун сумын Соёлын төвийн хувьд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил илрээгүй байсан тул түүвэрт хамруулж Шилэн дансны үйл ажиллагаа, мэдээлэлд хийх нийцлийн аудитаар шалгахаар шийдвэрлэв.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 140, хугацаа хоцрож 11 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна.

### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд зөрчилтэй асуудал байхгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
20
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 31,556.1 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 31,556.1 мянган төгрөгийн алдааг залруулла.

### 4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

Аудитаар Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт заасныг зөрчин дотоод томилолт, нэг удаагийн тэтгэмж шагнал урамшууллын зардлыг шууд зардалд бүртгэсэн 31,556.1 мянган төгрөгийн алдаа зөрчлийг залруулла.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
20
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Баруунтуруун сумын Соёлын төв | 1 | 31,556.1 | 1 | 31,556.1 | | | | | | |
| **ДҮН** | | 1 | 31,556.1 | 1 | 31,556.1 | | | | | | |

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР /М.БАТСУУРЬ/

АУДИТЫН МЕНЕЖЕР /М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН: АУДИТОР /Р.АЮУШ/

2022 оны 02 сарын 15-ны өдөр

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
20
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ